

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2019 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2019.10.26-2019.11.25/

2019 оны 11 дүгээр сарын 26-ний өдөр

Дорнод аймаг

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хийгдэх ажил	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
Нэг. Захиргаа, удирдлагын чиглэлээр				
1	Байгууллагын даргын болон бусад холбогдох нэгжээс ирүүлсэн үүрэг даалгавар, албан даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг гаргаж хүргүүлэх	а/ Албан хаагчдад хүргүүлж, үүрэг даалгавар өгөх б/ Хэрэгжилтийг тухай бүр хангах в/ Холбогдох албан тушаалтанд тайлагнах	Байгууллагын дарга, удирдлагуудаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах санал, хөдөлмөрийн дотоод журамд оруулах саналыг захиргаа удирдлагын газрын болон эрх зүй гадаад харилцааны хэлтсийн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн. Мөн хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст бүсийн газрын 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, байгууллагын даргын 2017, 2018, 2019 оны албан даалгавруудын биелэлт, 11 дүгээр сард хийх ажлын төлөвлөгөө, Ерөнхий сайдын айлчлалын талаар 01-12/128 дугаар бүхий илтгэх хуудас зэргийг тус тус хүргүүлсэн.	100%
2	Эрээнцав боомтын амралтын байранд засвар үйлчилгээ хийж, нөхцлийг сайжруулах	а) Эд материалын тооцоо гаргах б) Засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх в) Үг дүнг удирдлагад танилцуулах	Эрээнцав боомтын амьдрах байранд 14 нэр төрлийн 36 ширхэг 266,089 төгрөгийн үнэ бүхий барилгын материал нэмж худалдан авалт хийн шал, тааз, ханаасаа хүйтэн салхи орж байсныг өөрсдийн албан хаагчдаар янзлуулан урсгал засвар үйлчилгээ өвлийн бэлтгэл ханган албан хаагчдын ажиллах, нөхцөл боломжийг сайжруулсан.	100%

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

Б.ТАМИР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

С.МӨНХЖАРГАЛ

